

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

“Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт үнэлгээ
болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг
шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох болон актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 212, 2008 оны 41, 2011 оны 335 дугаар тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай

3. Хавсралтаар шинэчлэн батлагдсан “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянан шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

З.НАРАНТУЯА

**АКТУАРЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭРХ ОЛГОХ,
АКТУАРЫН СТАНДАРТ ҮНЭЛГЭЭ БОЛОН АКТУАРЧИЙН
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ, ТАЙЛАН ГАРГАХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос гаргасан заавар журмыг мөрдлөг болгоно.

**ХОЁР. Актуарчийн үйл ажиллагаа
эрхлэх эрх олгох**

2.1. Дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн (цаашид “этгээд” гэх)-д актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг Даатгалын зохицуулалтын газрын саналыг үндэслэн Хорооны даргын тушаалаар олгоно:

- 2.1.1. Эдийн засагч, статистикч, санхүүч, математикч, эдийн засгийн математик загварчлал зэрэг мэргэжлээр их дээд сургуулийн хөтөлбөрийг хангасан;
- 2.1.2. Актуарын чиглэлээр гадаадын болон дотоодын тусгай курс, сургалтад суралцаж төгссөн;
- 2.1.3. Олон улсын актуарчдын холбоо болон түүний жинхэнэ гишүүн байгууллагаас зохион байгуулсан магадлалын онол болон санхүүгийн математик сэдвийн хүрээн дэх шалгалтыг эсхүл түүнтэй дүйцэхүйц дотоодын шалгалтыг өгч тэнцсэн;

2.2. Хороо олон улсын актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан этгээдэд энэхүү журмын 2.1.1-2.1.3 дахь шаардлагыг хангасан эсэхээс үл хамааран актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгож болно;

2.3. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь энэхүү журмын 5.3.4-т заасан үндэслэлээр хүчингүй болгосноос хойш 6 сар, бусад үндэслэлээр хүчингүй болгосноос хойш 1 жилийн хугацаа өнгөрсөн бол түүнд актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дахин олгож болно.

2.4. Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах чиглэлээр олгоно:

2.4.1. Урт хугацааны даатгалын;

2.4.2. Ердийн даатгалын.

2.5. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авахыг хүссэн этгээд өргөдлөө энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаж байгааг нотолж баталгаажуулсан баримтын хамт Хороонд ирүүлнэ.

2.6. Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгохыг хүссэн этгээдийн ирүүлсэн баримт бичгийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг магадлах зорилгоор холбогдох байгууллагаас бичгээр тодруулга авч болно.

2.7. Актуарчийг энэ журмын 2.3-д заасан чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж, мөн энэ хугацаанд мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэн Олон улсын актуарчдын холбоо болон түүний жинхэнэ гишүүн байгууллагаас зохион байгуулсан магадлалын онол, санхүүгийн математик сэдвийн хүрээний болон дараагийн шатны шалгалтуудыг амжилттай өгсөн буюу тухайн чиглэлээр хангалттай туршлагажсан гэж үзвэл Хороо мэргэшсэн актуарчийн эрхийг олгож болно.

ГУРАВ. Актуарын үйл ажиллагааны стандарт үнэлгээ

3.1. Актуарч нь үйл ажиллагаандаа актуарын дараах стандарт үнэлгээг хэрэгжүүлнэ:

3.1.1. Даатгалын үнэлгээ, эрсдэл дээр үндэслэсэн даатгалын хураамжийн хувь хэмжээг тооцох;

3.1.2. Даатгалын нөөцийн сан, даатгалын компанийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцох;

3.1.3. Тухайн даатгалын компанийн санхүүгийн жилийн эцэст даатгалын гэрээнээс үүссэн үүрэг болон нөхөн төлбөрийг тооцох;

3.1.4. Тухайн даатгалын компанийн санхүүгийн жилд даатгалын сангуудтай холбоотой даатгагчийн хүлээсэн үүрэгт гарсан өөрчлөлт болон холбогдох үзүүлэлтийг үнэлж тооцох;

3.1.5. Даатгагчийн боловсруулсан даатгалын шинэ бүтээгдэхүүний хураамжийн хувь хэмжээг тооцох;

3.1.6. Даатгагчийн төлбөрийн чадварын түвшинд үндэслэн санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо судалгаа хийх.

3.1.7. Давхар даатгалын хуваарилалт, эрсдэлийн тооцоо, хөрөнгийн хүрэлцээг үнэлэх;

3.1.8. Хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, үнэлэлт өгөх;

3.1.9. Ашгийн зохистой хуваарилалтын дүгнэлт гаргах.

ДӨРӨВ. Актуарын хяналт шалгалт хийх, тайлан гаргах

4.1. Даатгалын компани энэхүү журмын 3 дугаар бүлэгт заасан актуарын үйл ажиллагааны үнэлгээ, хяналт шалгалтыг жил бүр хийлгүүлнэ.

4.2. Актуарч нь энэхүү журмын хавсралтаар батлагдсан “Актуарын тайлангийн стандарт”-д заасны дагуу актуарын хяналт шалгалтын тайланг бэлтгэнэ;

4.3. Актуарч нь тухайн компанид актуарын шалгалтыг жилд 1 удаа хийх ба жилийн эцсийн санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор хийж, 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор даатгагч болон Хороонд хүргүүлнэ.

4.4. Хороо актуарчийн ирүүлсэн тухайн даатгалын компанийн актуарын шалгалтын тайлан, дүгнэлтийг хүлээн авч, хянах бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн актуарчийн хийсэн дүгнэлтийн талаар тодруулга тайлбар авч болно.

ТАВ. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

5.1. Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

5.1.1. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хуурамч баримт бичиг бүрдүүлэх замаар авсан болох нь тогтоогдсон;

5.1.2. Актуарч нь актуарын хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтээ гаргахдаа зах зээлийн болон даатгагчийн бодит тоон мэдээлэлд үндэслээгүй, алдаатай гаргасан болох нь тогтоогдсон;

5.1.3. Хорооны улсын байцаагчийн актуарын үйл ажиллагаагаа хангалтгүй биелүүлж байна гэж үзэж удаа дараа алдаагаа засах талаар өгсөн шаардлагыг биелүүлэгүй;

5.1.4. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх авснаас хойш даатгалын компани эсхүл төрийн байгууллагад актуарчаар /мэргэжлээрээ/ тасралтгүй 6 сар ажиллаагүй;

5.2. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

5.2.1. Хорооноос тогтоосон 6 сар хүртэл хугацаагаар;

5.2.2. Хорооноос өгсөн хугацаатай үүрэг даалгавар, албан шаардлагыг биелүүлэх хүртэл.

5.3. Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

5.3.1. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд өөрөө хүсэлтээ гаргасан;

- 5.3.2. Актуарчийн үйл ажиллагаагаа хангалтгүй хэрэгжүүлж, Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, багц дүрмийг ноцтой зөрчсөн;
- 5.3.3. Түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан албан шаардлага, үүрэг даалгаврыг биелүүлээгүй;
- 5.3.4. Энэ журмын 5.1.4-т заасан үндэслэлээр эрхийг нь түдгэлзүүлснээс хойш 3 сарын дотор аль нэг даатгалын компани эсхүл төрийн байгууллагад актуарчийн албан тушаалд томилогдоогүй.

5.4. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд өгсөн үүрэг даалгавар, албан шаардлагыг биелүүлж ажилласан гэж үзсэн тохиолдолд Хороо актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг сэргээж болно.

ЗУРГАА. Бусад

- 6.1 Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд актуарчаар томилогдох, чөлөөлөгдөх, шилжин ажиллах бүртээ эрх бүхий албан тушаалтнаар холбогдох тушаал /шийдвэр/-ыг гаргуулан, нийгмийн даатгалын дэвтэртээ бичилт хийлгэн баталгаажуулж, хуулбаруудыг ажлын 5 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

ДОЛОО. Хүлээлгэх хариуцлага

- 7. Актуарч нь өөрийн хийсэн актуарын хяналт, шалгалтын тайлан, дүгнэлтийн үнэн зөв байдалд холбогдох хууль журамд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

7.1. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- оОо -----

“Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт үнэлгээ болон актуарчийн хяналт, шалгалт хийх, тайлан гаргах журам”-ын хавсралт

АКТУАРЫН ТАЙЛАНГИЙН СТАНДАРТ

1. Актуарч даатгагчийн актуарын тайланг бэлдэхдээ энэхүү стандартын дагуу боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

2. Актуарын тайлан нь дараах агуулгатай байна.

Дугаар	Сэдвийн нэр
1	Удиртгал
1.1	Зорилго
1.2	Хамрах хүрээ
1.3	Тайланг бэлтгэхэд ашигласан удирдамж
2	Нэр томъёоны тайлбар
3	Актуар тооцооллын үр дүн
3.1	Хохирол нөхөлтийн харьцаа
3.2	Даатгалын хураамжийн хувь
3.3	Даатгалын нөөц сан ба Төлбөрийн чадварын тухай
3.4	Ашигт ажиллагааны тухай
3.5	Учирч болзошгүй эрсдэлийн тооцоо
3.6	Өмнөх тайлангаар өгсөн актуарчийн зөвлөмжийн биелэлт
3.7	Тооцоололд ашигласан аргачлал /“гурвалжингийн арга”/, загварууд
4	Тооцоололд ашигласан тоон мэдээлэл
4.1	Даатгагчаас авсан мэдээлэл
4.2	Бусад эх сурвалжаас авсан мэдээлэл
5	Актуарын дүгнэлт
6	Актуарын зөвлөмж
7	Хавсралтууд

3. Актуарын тайлангийн агуулгад дурьдсан нэрсийг дараах байдлаар ойлгоно.
Үүнд:

3.1. Зорилго гэдэгт тухайн тайланг бичиж буй зорилгыг тодорхойлох бөгөөд тайланг хэн захиалсан, гүйцэтгэж буй актуарчдын нэр, туршлага зэрэг мэдээллийг багтаана.

3.2. Хамрах хүрээ гэдэгт тайлангийн хэрэглээг чухалчлан дурьдана.

3.3. Тайланг бэлтгэхэд ашигласан удирдамж гэдэгт актуарын тайлангийн стандарт болон Даатгалын багц дүрэмд харшлаагүй заавар зөвлөгөөг дагаж мөрдсөн тухай бичнэ.

3.4. Актуар тооцооллын үр дүн гэдэгт актуарч дээрх хүснэгтийн 3.1-3.7 дахь тооцооллын үр дүнг заавал харуулна.

- 3.5. Тооцоололд ашигласан тоон мэдээлэл гэдэгт ашигласан мэдээллийн бодит байдал, хүчинтэй хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээг оруулна.
- 3.6. Дүгнэлт нь актуарчийн хяналт шалгалтаар тухайн даатгагчийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт бөгөөд бие даасан хараат бус шинжтэй байна.
- 3.7. Зөвлөмж гэдэгт актуарч нь хяналт шалгалтаар цаашид анхаарах, авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн тухай зааж өгнө.
- 3.8. Санхүүгийн тайланд тусгагдаагүй үр дүн болон актуар тооцооллын хавсралтуудыг оруулна.

----- oOo -----